3.3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улиралд сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр, стандартын шаардлага хангасан хийн болон цахилгаан халаагуур, бүрэн шаталттай шахмал түлш ашиглах

3.4. Зориулалтын (2-3 хоногийн багтаамжтай) хогийн савтай байж, бохир усны цооног, бие засах газрыг стандартын шаардлага хангасан хөрс бохирдуулахгүй байдлаар шийдэх

3.5. Орон нутгийн нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн тодорхой үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх

3.6. Дүүрэгт ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний 80 хүртэлх хувьд дүүргийн харьяалалтай иргэдийг хамруулж, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулан, чадваржуулах ажлыг зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл болон, тухайн дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьж, ажлын байран дахь аюул

эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллах

3.8. Ажилчдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу цаг хугацаанд нь хамруулах

3.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №36 дугаар тушаалаар батлагдсан/

Дөрөв. Гэрээ дуусгавар болох

Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд

4.1. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө тал нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

4.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.

4.3. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.

4.4. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

Тав. Нэмэлт нөхцөл

- Хог хаягдлыг эрхт О.СТА мандайд хамгаажуулах материал, тавт, айр
- Засвар мандайд 50м мөс марж өгнө. /мөс авт өгнө/

Зургаа. Гэрээний хариуцлага, дүгнэх

6.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хийж, оны эцэст үр дүнг тооцож гэрээг дүгнэнэ.

6.2. Дүүргийн ойн арга хэмжээ болон дүүргийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг талууд харилцан зөвшилцөж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын "Зөрчлийн тухай", "Хог хаягдлын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээгээр хүлээсэн үүргээ давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагатай хамтран бүрэн зогсоох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Н.МАНДУУЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

9105352 111714754

ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТУНГАЛАГ

2023 оны 04 сарын 03 өдөр

УТАС: 70232419

9105352 111714754

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

"Делем" ХХК-ийн ЗАХИРАЛ З.Баярсайхан

2023 оны 04 сарын 03 өдөр

УТАС:


"Делем" ХХК-ийн Ерөнхий менежер

Б.Ундурмаа

2023 оны 04 сарын 03 өдөр

УТАС:

8810-3666

БАТЛАВ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ОНЦГОЙ
КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА
ХУРАНДАА  Л.ЧИНБАТ

2023 оны 05 дугаар сарын 02

1118121164
УДГ0004 9102957

БАТЛАВ
“ЭЛЕМЕНТ” ХХК ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ  З.БАЯРСАЙХАН

2023 оны 05 дугаар сарын 02

ҮҮССЭН БОЛОН ҮҮСЧ БОЛЗОШГУЙ ГАМШИГ, ТОМООХОН ХЭМЖЭЭНИЙ АЮУЛТ
ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ҮЕД ХАМТРАН АЖИЛЛАХ,
ДАЙЧИЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

Дугаар ...

Энэхүү гэрээг нэг талаас Налайх дүүргийн Онцгой комиссыг төлөөлж Онцгой байдлын хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч бөгөөд Онцгой комиссын нарийн бичгийн дарга, хошууч Т.Пүрэвдорж (цаашид “дайчилгаа зохион байгуулагч тал” гэх), нөгөө талаас регистрийн 2100061, улсын бүртгэлийн 9011082081 дугаартай “Элемент” ХХК-ийг төлөөлж Д.Өлзий (цаашид “дайчлагдан ажиллах тал” гэх) нар (хамтад нь “талууд” гэх) дараах нөхцлөөр харилцан тохиролцож, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ын 1.6, 2.1, 2.2, 3.2, 4.1.1, 4.1.4, 4.2.1, 4.3.1, 4.3.3, 5.2, 5.4-т заасныг тус тус үндэслэн байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго: Үүссэн болон үүсч болзошгүй гамшиг, томоохон хэмжээний аюулт үзэгдэл, ослын үед голомтод үүрэг гүйцэтгэхээр дайчлагдах өөрийн байгууллагын хүн хүч, тээврийн хэрэгсэл, барилга байгууламжийн бэлэн байдлыг хангах, тухайн шатны Засаг дарга, Онцгой комисс, мэргэжлийн байгууллагын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, талуудын эрх, үүргийг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Байгууллагаас дайчлагдан ажиллах хүн хүч, тээврийн хэрэгслийн бэлэн байдал, бүрэн бүтэн байдал хангагдсан, үүрэг гүйцэтгэх чадамжтай байна.

1.3. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам болон гэрээгээр зохицуулаагүй харилцаанд бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.4. Энэхүү гэрээ болон түүний хавсралтууд нь гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж, гэрээг цуцлах хүртэл хугацаанд талуудын хоорондын бүхий л харилцааг зохицуулах хууль эрхзүйн баримт бичиг болно.

1.5. Гэрээний хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 02 -ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын сарын 02 -ны өдрийг хүртэл хүчинтэй байна.

Хоёр. Төсөв, зардал

2.1. Дайчилгаа зохион байгуулагч тал нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журмын 4.1.4, 5.2-т заасны дагуу дайчлан ажиллуулах үеийн зардал, нөхөн олговрыг мөрдөж байгаа жишиг үнийн дагуу орон нутгийн төсвөөс гарган дайчлагдан ажиллах талд олгоно.

2.2. Дайчилгааны үеийн бүх төрлийн хангалтыг тухайн үеийн үнэ, ханшаар тогтооно.

2.3. Зардал, нөхөн олговор, хангалтыг дайчлагдан ажиллах талын нэхэмжлэхийг үндэслэн тухайн байгууллагын дансанд шилжүүлэх, эсхүл шаардлагатай тохиолдолд бэлнээр олгоно.

2.4. Дайчилгааны үеийн гамшгийн голомт дахь үйл ажиллагаатай холбоотой (нурангид дарагдах, гал түймэрт өртөх, үерийн усанд автах гэх мэт)-гоор автомашин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид үүссэн эвдрэл гэмтлийг засварлахад шаардагдах зардлыг дайчилгаа зохион байгуулагч тал олгох бөгөөд засвар үйлчилгээг дайчлагдан ажиллах тал зохион байгуулна.

Гурав. Дайчилгаа зохион байгуулагч талын эрх, үүрэг

3.1. Дайчлагдан ажиллах талын удирдлагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шаардах;

3.2. Дайчлагдан ажиллах талын хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг шалгах, мэдээ, мэдээллийг авах, зааварчилгаа өгөх, хяналт тавих;

3.3. Жилд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүрт хүч хэрэгслийн тооцоог дайчлагдан ажиллах талаас гаргуулж авах;

3.4. Бэлтгэл, бэлэн байдлыг хангахад үүссэн доголдлыг арилгуулах тухай шаардлагыг дайчлагдан ажиллах талд хүргүүлж, биелэлтэд хяналт тавих;

3.5. Голомтод дайчлагдан ажиллах үеийн зардал, нөхөн олговрыг мөрдөж байгаа жишиг үнийн дагуу шуурхай шийдвэрлэж дайчлагдан ажиллах талд олгох;

3.6. Дайчлагдан ажиллах талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

Дөрөв. Дайчлагдан ажиллах талын эрх, үүрэг

4.1. Дайчилгаа зохион байгуулагч талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

4.2. Үүссэн болон үүсч болзошгүй гамшиг, томоохон хэмжээний аюулт үзэгдэл, ослын үед голомтод үүрэг гүйцэтгэх зорилгоор дайчилгаа зохион байгуулагч талын шийдвэрийн дагуу хүн хүч, техник хэрэгслийг дайчлан шуурхай шилжин байрлаж үүрэг гүйцэтгэх;

4.3. Голомтод үүрэг гүйцэтгэх үеийн өөрийн байгууллагын хүн хүч, техник хэрэгслийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, хяналт тавьж ажиллах;

4.4. Хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангасан тухай дайчилгаа зохион байгуулагч талд мэдэгдэх, талаас хяналт тавих нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллах;

4.5. Жилд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүрт хүч хэрэгслийн тооцоог дайчилгаа зохион байгуулагч талд гаргаж өгөх;

4.6. Дайчилгаа зохион байгуулагч талаас бэлтгэл, бэлэн байдлыг хангуулахаар шаардсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

4.7. Дайчилгаа зохион байгуулагч талаас голомтод дайчлагдан ажиллах үеийн зардал, нөхөн олговрыг мөрдөж байгаа жишиг үнийн дагуу шаардан гаргуулж авах;

4.8. Дайчилгаа зохион байгуулагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

Тав. Талуудын хариуцлага

5.1. Талууд холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргээ ухамсарлаж, эх оронч сэтгэлгээгээр асуудалд хандаж, шийдвэрлэнэ.

5.2. Гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал учирсан хохирол, алдагдлыг үл маргах журмаар барагдуулна.

5.3. Хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан, биелүүлэхгүй байхыг бусдад уриалсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1. Гэрээний нөхцөлөөс үүдэн гарч болох аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.2. Хэрэв харилцан тохиролцох боломжгүй болон татгалзсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээнд өөрчлөлт оруулах

7.1. Зайлшгүй шаардлага үүссэн нөхцөл байдалд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлтийг оруулж болно.

7.2. Гэрээнд өөрчлөлт оруулах саналыг талууд албан бичгээр хандаж шийдвэрлэнэ.

7.3. Дайчлагдан ажиллах тал гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас дайчлагдан ажиллах техник хэрэгслүүдэд эвдрэл гэмтэл үүсч, үүрэг гүйцэтгэх бүрэн чадамжгүй, боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн үүссэн нөхцөл байдлыг даван туулах, сэргээн босгох хүртэл хойшлуулж болно.

7.4. Энэхүү гэрээний 7.3-т заасан нөхцөл байдал үүссэн, сэргээн босгох ажиллагаа хийгдэж дууссан тухай эрх бүхий байгууллагаас гаргасан баримт нотолгоог үндэслэн талууд албан бичгээр мэдэгдэнэ.

Найм. Бусад нөхцөл

8.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хүч хэрэгслийн тооцоог хавсарган, талууд тус бүрт 1 хувийг хадгална.

8.2. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээний хугацаанд хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлснээр дуусгавар болно.

8.3. Бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ОНЦГОЙ
БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ОРЛОГЧ,
ХОШУУЧ
Т.ПҮРЭВДОРЖ

ХАЯГ: НАЛАЙХ ДҮҮРЭГ 8 ДУГААР
ХОРОО ДАМДИНЫ ГУДАМЖ ОНЦГОЙ
БАЙДЛЫН ХЭЛТЭС
УТАС : 8932 2101

"ЭЛЕМЕНТ"
АЖИЛТАН

ХХК-ИЙН

ХАБЭА-Н

Д.ӨЛЗИЙ

ХАЯГ: НАЛАЙХ ДҮҮРЭГ 3-Р ХОРОО
БҮС НУУР ХҮЧИЛТӨРӨГЧИЙН
ГУДАМЖ
УТАС : 80696446, 88103666.
И-МЭЙЛ: element.llcmgl@yahoo.com



2022 оны 9 сарын 12 ны өдөр

№

Налайх дүүрэг

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГЭРЭЭ

НЭГ. Нийтлэг үндэслэл

Энэхүү урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г

Нэг талаас: Улаанбаатар хот, Налайх дүүрэг 2 дугаар хороо Дамдины хаягт орших, 9102914 тоот регистрийн дугаартай "НАЛАЙХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ" (цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэж нэрлэх),

Нөгөө талаас: "Элемент" ХХК орших 2/00061 тоот регистрийн дугаартай Энхэл Ганзориг аюулгүй орчин хөгжүүлэх үйлчилгээ (цаашид "Үйлчилүүлэгч гэх" гэж нэрлэх), гэх талууд Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хууль, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй орчин эрүүл ахуйн тухай хуулийн 12 зүйлийн 12.1 заалт 14 зүйлийн 14.1, 14.2 заалтууд холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. Ерөнхий зүйл

- 2.1. Энэхүү гэрээ нь аж ахуй нэгж байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд /Цаашид "урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ" гэх/ хамааруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 2.2. Тухайн байгууллагын нийт ажилчдыг нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажилчдынхаа эрүүл мэндийн байдалд судалгаа хийж дүгнэлт гаргуулах, түүний дагуу гарсан өвчлөлийг шат дараатайгаар эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа хийх
- 2.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг нөгөө талдаа 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ. Нэмэлт өөрчлөлт хавсралт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнтэй нэгэн адил хүчинтэй байна.
- 2.4. Талуудын аль нэг нь гэрээг цуцлах тухай санал гаргавал нөгөө талдаа 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх ба талууд харилцан зөвшилцөж, хийгдсэн ажлыг хүлээлцэж төлбөр тооцоог дуусгаснаар гэрээг цуцалсанд тооцно.
- 2.5. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно

ГУРАВ. Эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага

- 3.1. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг холбогдох стандарт арга, аргачлалын дагуу үнэн зөв, бүрэн хийнэ.
- 3.2. Үзлэг шинжилгээний үр дүнг эмч болон эмнэлгийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.
- 3.3. Эрх бүхий албан тушаалтныг тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тушаалаар томилж, гарын үсгийн тайлал болон тэмдгийн загварыг баталгаажуулсан байна.
- 3.4. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн “эерэг” гарсан ажилтныг эмчилж, эрүүлжүүлэх арга хэмжээг авна.
- 3.5. Эрүүл мэндийн дэвтэр болон үзлэгийн хуудсыг батлагдсан загварын дагуу хэвлүүлж ашиглана.

ДӨРӨВ. Ажил олгогчид тавигдах шаардлага

- 4.1. Ажилтныг заасан хугацаанд эрүүл мэндийн байгууллагатай гэрээ хийж урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамааруулна.
- 4.2. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн “эерэг” гарсан ажилтнуудыг эмчилж, эрүүлжүүлэх, хөдөлмөр зохицуулалт хийх ажлыг Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 4.3. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байдал, баталгаажуулалтад хяналт тавьж ажиллана.

ТАВ. Ажилтанд тавигдах шаардлага

- 5.1. Халдварт өвчнөөр өвчилсөн буюу өвчтөнтэй хавьтал болсон тохиолдолд тухай бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана.
- 5.2. Ажилтан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэр бичигдсэн санамж зөвлөмжтэй танилцаж гарын үсэг зурж, санамжийг мөрдөж ажиллана.
- 5.3. Дэвтэр болон үзлэгийн хуудсыг хуурамчаар үйлдэх, засварлах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

ЗУРГАА. Талуудын эрх, үүрэг

6.1. Үйлчлүүлэгчийн эрх

- 6.1.1. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг үйлчилгээ үзүүлэгчээс шаардах
- 6.1.2. Үйлчлүүлэгч хүсвэл байгууллагын ажилчдын шинжилгээний дүн болон дүгнэлтээр илэрсэн голчлох өвчлөлөөр эрүүл мэндийн сургалт хичээл авах
- 6.1.3. Гэрээт ажлын явц, чанарт байнгын хяналт тавих Үйлчилгээ үзүүлэгчтэй харьцах эрх бүхий ажилтныг томилон ажиллуулах эрхтэй
- 6.1.3 Үйлчилгээ үзүүлэгчийг хөдөлмөр хамгааллын болон техникийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг шаардах эрхтэй.

6.2. Үйлчлүүлэгчийн үүрэг

- 6.2.1. Гэрээнд заасны дагуу төлбөрийг төлөх
- 6.2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх
- 6.2.3. Үйлчлүүлэгч санал гаргаж байгууллага дээр үзлэг хийх тохиолдолд үзлэг хийх өрөө, тасалгаа болон ширээ сандлыг урьдчилан бэлдсэн байна

6.3. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх

- 6.3.1. Үйлчлүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах
- 6.3.2. Үйлчилгээний төлбөрийг тусламж үйлчилгээний төрлөөр гэрээнд заасан хугацаанд багтаан төлөхийг Үйлчлүүлэгчээс шаардах;
- 6.3.3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний хугацааг товлон мэдээлэл хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүй хугацаандаа үзлэгт хамрагдаагүй ажилтан албан хаагчийн гомдлыг үйлчилгээ үзүүлэгч тал хариуцахгүй

6.4. Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг

- 6.4.1. Үйлчилгээ үзүүлэгч нь урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх хугацаанд ажиллах хүчний дэг журам, сахилга бат, хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллыг бүрэн хариуцах болон гүйцэтгэж буй ажлын аюулгүй байдлыг ханган ажиллана.
- 6.4.2. Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын ажилтан урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ нь стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлж буйд дангаараа ба зохих эрх бүхий байгууллагатай хамтран үзлэг шалгалт хийх үүрэгтэй.
- 6.4.3. Ажлын байрны дасгал хөдөлгөөн, хийн дасгалыг гэрээ хийсэн байгууллагад 1-2 удаа мэргэжлийн багш, арга зүйч нар зааж өгнө.

ДОЛОО. Гэрээний хугацаа

- 7.1. Гэрээ нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох, эсхүл гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар дуусгавар болно.
- 7.2. Гэрээний хугацаа нь 1 жил байна.
- 7.3. Талууд энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд тэдгээр нь хууль эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.4. Энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцож гэрээ болон гэрээний хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Гэрээний бүх хавсралт энэхүү гэрээний салшгүй хэсэг нь байна.
- 7.5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.
- 7.6. Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, ерөнхий болон гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид болон өмчлөгчид өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ үйлчлэх хугацааны турш хүчин төгөлдөр байна.
- 7.7. Талуудын хариуцсан ажилтан өөрчлөгдөх тохиолдолд тухайн холбогдох хаягийг гэрээний хавсралтаар оруулж өөрчилнө.
- 7.8. Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг Талууд биечлэн болон албан бичигтелефон утас, албаны имэйлээр харилцана.
- 7.9. Нууц хадгалах: Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн мэдээллийг шууд буюу шууд бусаар буруугаар ашиглах болон гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

НАЙМ. Үйлчилгээний төлбөрийн нөхцөл.

- 8.1. Сангийн Сайд болон Эрүүл Мэндийн Сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 49А/118 дугаар “Төлбөртэй тусламж үйлчилгээний журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 8.2. Үйлчлүүлэгч урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөрийг бэлнээр болон дансаар төлж болно. Данс: **Төрийн сан банк 100200420001**
- 8.3. Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 1 хүний **80.000** төгрөг
- 8.4. Гадаад иргэний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 1 хүний **130.000** төгрөг

- 8.5. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээтэй 1 хүний 57.000 төгрөг. Энэ төлбөрт рентген, эхо ороогүй болно. /рентген 30.000 төгрөг, хэвлийн эхо 25.000 төгрөг/ Нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээгүй 20.000 төгрөг байна.
- 8.6. Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах 80.000 төгрөг
- 8.7. Гэр бүл болох, ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах 80.000 төгрөг
- 8.8. Буу галт зэвсэг эзэмших сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах 20.000 төгрөг
- 8.9. Жолоочи йн үнэмлэх авах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах 50.000 төгрөг
- 8.10. Захиалагч байгууллага нь урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөр болох 70 хувийг шинжилгээнд орохын өмнө тушаасан байх. Үлдсэн хувийг үзлэг дуусахаас өмнө тушаасан байна.

ЕС. Маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Гэрээтэй холбогдох аливаа маргаантай асуудлыг талууд эв зүйгээр зохицуулахыг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх тохиолдолд шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

АРАВ. Давагдашгүй хүчин зүйл

- 10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл /Дайн байлдаан, иргэдийн бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөл, бүслэлт, тээврийн хориг, газар хөдлөлт, ус, үер, гал түймэр, салхи шуурга/-ийн улмаас Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол тодорхой хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг Талууд тохиролцон сунгаж болно.

АРВАН НЭГ. Бусад

- 11.1. Гэрээ нь талуудын эрх, ашиг сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 11.2. Гэрээний хавсралт нь түүний салшгүй хэсэг байна. Хэрэв гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр бичгээр үйлдэх бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.3. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 11.4. Энэ гэрээ нь хавсалтын хамт нийт 7 (долоо) хуудас, үндсэн эхийг Монгол хэл дээр 2 хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

НЭМТӨВИЙГ ТӨЛӨӨЛӨН:
СТРАТЕГИ-ТӨЛӨВЛӨЛТ, ГАДААД
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН ОРЛОГЧ
ДАРГА *[Signature]* С.МАНАТБЕК

УТАС: 99071725

2022 оны 09 сарын 12

ТӨЛӨӨЛӨН:
[Signature] -ийн
ДАРГА /ЗАХИРАЛ, МЕНЕЖЕР/
[Signature]
УТАС: 88861019 85010584
2022 оны 9 сарын 12

Үзлэг 2 үе шаттайгаар явагдана

1. Шинжилгээний үе шат
2. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн үе шат

Эмч нарын үзлэг хийх зарчим

1. Амин үзүүлэлт үзнэ / хуудсанд тэмдэглэнэ /
 - 1.1 Артерийн даралт
 - 1.2 Зүрхний цохилт
 - 1.3 Амьсгал тоолох
 - 1.4 Халуун үзэх
 - 1.5 Цусны хүчилтөрөгчийн багтаамжийг сувилагч үзэж Картанд тэмдэглэнэ.
2. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг
 - 1.1 Дотрын- Зүрх судасны эмчийн үзлэг
 - 1.2 Мэдрэл- Сэтгэцийн эмчийн үзлэг
 - 1.3 Мэс засал- Гэмтлийн эмчийн үзлэг
 - 1.4 Нүдний эмчийн үзлэг
 - 1.5 Чих хамар хоолойн эмчийн үзлэг
 - 1.6 Шүдний эмчийн үзлэг
 - 1.7 Халдварт-Сүрьеэгийн эмчийн үзлэг
 - 1.8 Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг
 - 1.9 Арьс- БЗДХ- эмчийн үзлэг

Оношилгоо шинжилгээний хэсэг

1. Лабораторийн шинжилгээ
 1. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
 2. Шээсний шинжилгээ
 3. Биохимийн шинжилгээ
 - 3.1.Элэгний үйл ажиллагаа /алат, асат, билирубин/
 - 3.2 Вирус үзэх /В, С/
 - 3.3.Бөөрний үйл ажиллагаа /мочевин, креатинин /
 - 3.4.Сахар
 - 3.5.Серологи /Тэмбүү, HIV,TPH/
 - 3.6.Үе мөчний идэвхжил /асло, c-peac/б, PP/
 - 3.7.HP
 - 3.8.Амилаза
 - 3.9.Нийт уураг, Альбумин
 - 3.10.Жирэмсний тест
 - 3.11. Мазокийн шинжилгээ
2. Дүрс оношилгоо
 - 2.1.ЭХО цуллага эрхтэн харах
 - 2.2.Флор авах
 - 2.3 ЭКГрам-Зүрхний цахилгаан бичлэг
 - 2.4 Рентген зураг авах /шаардлагатай тохиолдолд/

1. Биохими цусны шинжилгээ өгөхөд анхаарах зүйл:

1. Өглөө өлөн ирж шинжилгээ өгнө
2. Хэт их өөх тостой хоол хүнс, чихэр шоколад хэрэглэх хэрэггүй.
3. Шинжилгээ өгөхөөс 15 минутын өмнө ирж тайван сууж байгаад шинжилгээ өгнө
4. Шинжилгээ өгөхөөс 2 цагийн өмнө тамхи татах эм уухыг хориглоно.
5. Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.
6. Урьд өдөр нь биеийн хүчний ажил болон спортын хүнд дасгал хийхгүй байх шаардлагатай.

2. Шээсний шинжилгээ өгөхөд анхаарах зүйлс:

1. Биеийн хүчний хүнд хөдөлмөр эрхэлдэг, биеийн тамир спортоор хичээллэдэг хүмүүс шинжилгээ өгөхөөс 3 хоногийн өмнөөс хүчний дасгал хийгээгүй байх. /явганаар удаан алхах бодибилдинг, фитнес г.м/
2. Шээсний шинжилгээ өгөхийн урд өдөр улаан манжин зэрэг будагч бодистой хүнс болон шоколад, кофе, сироп зэрэг хэт чихэрлэг зүйлийг хэрэглээгүй байх шаардлагатай.
3. Шил болон түүний таглааг маш сайн угааж хатааж тавина. Дутуу угааснаас үүдэн шил таглаанд наалдсан сахар шээстэй холилдож таны шинжилгээ буруу гарах бүрэн боломжтой.
4. Гадна бэлэг эрхтэнг сайтар угаах.
5. Өлөн шээснээс шинжилгээ авах ба түүний дунд гуравны нэгээс таслан авна /эхлэл болон төгсгөлийн шээсийг авахгүй/.
6. Шээсээ сайн таглаад гадна талд нь нэрээ гаргацтай тод бичиж наана.

3. Бусад шинжилгээ өгөхөд анхаарах зүйлс:

1. ЭХО-д харуулахдаа өлөн байна /Түрүү булчирхай, умай, дайвар өндгөвч харуулахад Шээстэй байна/
2. Биеэ арчих жижиг сальфетиктай ирнэ
3. ЭКГ /40-өөс дээш насныханд /хийлгэх хүн биедээ эзэмг бөгж гэх төмөр зүйлээ биеэсээ авсан байна.



3.БАЯРСАЙХАН



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 11 сарын 08 өдөр

№

Налайх

Энэхүү гэрээг Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 тоот заалтыг үндэслэн Нэг талаас Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн албан тушаалтай *С.Чинзориг* (цаашид "А" тал гэнэ), Нөгөө талаас "Элемент" ХХК түүнийг төлөөлж Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа (цаашид "Б" тал гэнэ) нар дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Гэрээнд оролцогч талууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон хавсралтанд заасан гэрээ, дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөнө.

1.1 Гэрээний талууд нь тус аюултай хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах чиглэлээр иргэн, байгууллага хоорондын зөрчил гарсан тохиолдолд хамтран ажиллаж, харилцан туслалцаа үзүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү гэрээ нь хог хаягдлыг бууруулах, ангилах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах ажиллагаанд гэрээнд оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хамтын ажиллагаатай холбоотой үүс болох аюул эрсдэлийн үед ажиллах харилцааг зохицуулна. Энэхүү гэрээнд талууд харилцан тэгш эрхтэйгээр оролцоно.

1.3 Энэхүү гэрээнд тусгагдсан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.4.1 "Хог хаягдал, хог хаягдал устгах, хадгалах, тээвэрлэх болон Аюултай хог хаягдал бусад нэр томъёог" Хог хаягдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.

1.4.2 "Гуравдагч этгээд" гэдгийг хог хаягдал тээвэрлэх, устгах, хадгалахтай холбоотой ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

1.4.3 "Үйлчилгээ үзүүлэгч тал" гэж "Элемент" ХХК-ийг ойлгоно.

1.4.4 “Оруулсан хөрөнгө оруулалт” гэж Хог боловсруулах төв байгуулах, хог тээвэрлэх болон бусад техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэхэд гарсан бүх төрлийн зардлыг ойлгоно.

1.4.5 “Аюултай хог хаягдал боловсруулах төвлөрсөн байгууламж” гэж аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, булшлах буюу ландфилл хийх, устгах чиглэлээр байгуулагдсан байгууламжийг ойлгоно.

ХОЁР. ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУГАЦАА

2.1 Хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараах байдлаар хариуцан зохион байгуулна.

2.1.1 Гэрээ хүчин төгөлдөр болмогц тус цагдаагийн хэлтэс нь “Элемент” ХХК-ний өдөр тутамын үйл ажиллагаанаас үүсч болох аюул эрсдэл, халдварт өвчин, байгалийн гамшигийн үед хамтран ажиллах, тусгаарлах, дараа дараачийн шатлалын байгууллагад мэдэгдэх, хорио цээр тогтоох зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

2.1.2 “Элемент” ХХК нь Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэстэй гэрээ байгуулсаны үндсэн дээр хог хаягдлыг устгах төвлөрсөн цэгийн байгууламжийн ажлыг эхлүүлэн ажиллана.

2.2 Гэрээний хугацаа талууд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 2 жил байна. Гэрээний талууд хамтран ажиллах гэрээг цуцлах, өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд тухай бүр шинэчлэлийг хийж болно.

2.3 Б тал нь 2.2 тоотод заасан хугацаа дуусахаас сарын өмнө дараагийн гэрээг баталгаажуулж ажиллана

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

“А” талын эрх үүрэг

3.1 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, аюултай хог хаягдлыг устгах, халдваргүй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах.

3.2 Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа Эрүүл Мэндийн байгууллагуудаас гарч байгаа Аюултай эрсдэлтэй хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 505 дугаар тушаалын дагуу устгах, тээвэрлэх ажлыг зохион байгуулж тухайн эрүүл мэндийн байгуулагуудтай тусад нь хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

3.3 ИТХ-ийн баталсан хог хаягдлын нормативийн дагуу иргэн, аж ахуй нэгж, байгууллагад мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

3.4 А тал нь тогтоосон маршрут, батлагдсан хуваарийн дагуу хог ачиж цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд хяналт тавих, заавар зөвлөгөө, чиглэл өгч ажиллана.

3.5 А тал нь хог хаягдлын талаар тогтоосон норматив хураамжийг төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагад хариуцлага тооцож, түргэн шуурхай нөхөн төлүүлэх талаар хамтран ажиллана.

3.6 Хог ачиж цуглуулах, тээвэрлэх, үйлчилгээтэй холбоотой иргэдийн санал, гомдол, хүсэлтийг шуурхай хүлээн авч, шуурхай шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжилж ажиллана.

3.7 “Элемент” ХХК-ий энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр бол тус компанитай харилцан санал солилцон шийдвэрлэж болно.

3.8 Зөвшөөрөлгүйгээр энэ төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагад хяналт тавьж, хуульд заасан хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллана.

3.9 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн үед шат шатны арга хэмжээ авч ажиллана.

“Б” талын эрх, үүрэг

3.10 “Элемент” ХХК нь Засаг даргын баталсан маршрутын дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн, хог хаягдал боловсруулах төвд хүргэж, ангилан ялгах, дахин боловсруулах, устгах ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.11 Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлаж байгаа Эрүүл Мэндийн байгууллагуудаас гарч байгаа Аюултай эрсдэлтэй хог хаягдалыг зохих журам, тушаалын дагуу устгах тээвэрлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг байршуулан ажиллана.

3.12 “Элемент” ХХК нь тухайн бүсийн айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийн хог хаягдлыг ачиж тээвэрлэх асуудлыг ИТХ-ийн шийдвэр, хог хаягдалын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

3.13 Гэрээний 3.10-д заасан үүрэгт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, хог хаягдал хамаарахгүй.

3.14 Хаягдал боловсруулах байгууламжийн ойр орчинд хоггүй цэвэр орчныг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

3.15 Хогийн төвлөрсөн цэгийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдлын журмыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно ажиллах

3.16 Айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд хог ачиж цуглуулах, хуваарийг тарааж, мэдээллэх, ухуулга сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах. Мэдээллэх хэлбэр нь дараах байдалтай байж болно. Амаар болон бичгээр танилцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах гэх мэт

3.17 Тухайн орон нутгийн албан байгууллага, аж ахуй нэгжүүдтэй “Хог тээвэрлэх гэрээ”-г бие даан санаачлан байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

3.18 Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, машин техник эвдэрсэн тохиолдолд хог ачиж цуглуулах хуваарийг алдагдуулахгүй байлгах зорилгоор сэлгэн ажиллуулах машин техникийн бэлэн байдлыг ханган ажиллана.

3.19 Аюултай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын байгууламжид устгах, хадгалах орчны эрүүл, аюулгүй байдлыг ханган ажиллана.

3.20 “Элемент” ХХК -ий зориулалтын тээвэрлэлтээс бусад тээврийн хэрэгсэлээр аливаа хуулийн этгээд хог хаягдлын боловсруулах төвийн ойролцоо зөвшөөрөлгүй газар хог хаягдлаа авч ирж хаясан зөрчил илэрвэл Засаг даргад мэдэгдэж Байгаль орчны хяналтын Улсын байцаагч торгууль шийтгэвэр тооцож хамтран ажиллана.

3.21 “Элемент” ХХК нь орон нутгийн бүх нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм журмыг чанд мөрдөж ажиллана.

3.22 “Элемент” ХХК нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй үйлчилгээ явуулах үүрэгтэй.

3.23 Иргэд, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд хогийг зөв боловсон хаях, ангилах талаар сургалт, семинар тогтмол графикын дагуу зохион байгуулах үүрэгтэй.

ДӨРӨВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

4.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас үүссэн нөхцөл байдлын үед хамтран ажиллана.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Талууд гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд үүргээ биелүүлж ажиллахыг нөгөө тал нь шаардах эрхтэй.

5.2 Дараагийн шатлалын байгууллагад гомдол гаргах эрхтэй.

ЁС. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА

9.1 Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

9.2 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.

9.3 Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.4 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

АРАВ. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД

А" тал

Налайх дүүрэг дэх Цагдаагийн
хэлтсийн *З.У.Т-ийн зөв*
.....албан тушаалтай
[Signature]
..... д/х С.Чимэддорж/

~~Тамга, тэмдэг~~

Хаяг, индекс:

Утас: 95041991



Б.Ундармаа /

Утас: 95576630, 88228757



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/A-25
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Элемент" ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.03.10
Дээжийн тодорхойлолт : Налайх дүүрэг 3-р хороо
Эмнэлэгийн аюултай хог хаягдал устгах газар
Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2023.03.13
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Нам даралтын зуух	III/10	10:50	0.030	0.098	0.215	68
2	Аюултай хог шатаах зуух	III/10	11:30	0.034	0.081	0.120	52
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015				2	2	2	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000							85

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр


Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

/Central inspection laboratory/
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 2-р хороо
Чингүнжавын гудамж Утас:70180075



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

/Test result of accredited laboratory/

TL 092
MNS ISO 17025

Захиалагчийн нэр /Customer name/: "Элемент"ХХК

Дээжн дугаар /Test number/	Дээжний хаяг, байршил /Sample location/			Уст цэгийн төрөл /Type of water/	
№ 200	УБ хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Бүс нуур 12610 гудамж, 77 тоот			Бохир ус	-
Дээжний тоо, хэмжээ /Quantity of the sample/	Дээж хүлээн авсан огноо /Date receipt/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/	Техникийн шаардлага / Technical requirements/ MNS 6561:2015	
1.5л / 1.5L /	2023.02.15	2023.02.15- 02.17	2023.02.17	Шинжилгээний аргын стандарт /Test method/ MNS ISO 11885:2011 /ICP/	

№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/	№	Үзүүлэлт /Parameters/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/
1	Манган, (Mn) мг/л /Manganese, Mn, mg/L /	-	<0.005	11	Хөнгөнцагаан, (Al), мг/л /Aluminum, Al, mg/L /	<0.5	<0.0094
2	Никель, (Ni) мг/л /Nickel, Ni, mg/L /	<0.5	0.0138	12	Лити, (Li) мг/л /Lithium, Li, mg/L /	-	<0.0058
3	Зэс, (Cu) мг/л /Copper, Cu mg/L /	<1.0	0.0006	13	Бари, (Ba) мг/л /Barium, Ba, mg/L /	-	0.0082
4	Кадми, (Cd) мг/л /Cadmium, Cd mg/L /	<0.05	<0.0098	14	Мөнгө, (Ag) мг/л /Silver, S, mg/L /	-	0.0001
5	Кобальт, (Co) мг/л /Cobalt, Co, mg/L /	<0.1	<0.0041	15	Бор, (B) мг/л /Bor, B, mg/L /	-	0.0005
6	Хар тугалга, Pb мг/л /Lead, Pb mg/L /	<0.2	<0.0134	16	Галли, (Ga) мг/л /Gallium, Ga, mg/L /	-	<0.001
7	Цайр, (Zn) мг/л /Zinc, Zn, mg/L /	<5.0	0.0054	17	Стронци, (Sr) мг/л /Strontium, Sr, mg/L /	-	0.0048
8	Нийт хром (Cr) мг/л /Chromium, Cr, mg/L /	<1.0	<0.004	18	Инди, (In) мг/л /Indium, In, mg/L /	-	<0.0131
9	Нийт төмөр (Fe) мг/л /Iron, Fe, mg/L /	<3.0	0.0043	19	Талли, Ta мг/л /Tallium, Tl mg/L /	-	<0.0133
10	Бисмут, (Bi) мг/л /Bismuth, Bi, mg/L /	-	<0.0034	20	Ванади, V мг/л /Vanadium, V mg/L /	-	<0.005

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:

Химич /Chemist/ Н. Халиунаа / N.Haliunaa.N/

Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч/ Head of laboratory/ Д.Мөнхзул / Munkhzul D MSc/

Хуудас1/1



ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Захиалгын дугаар : ХФ 2023/0175
 Захиалагчийн нэр : Элемент ХХК
 Объект : -
 Хаяг : Налайх дүүрэг, 3-р хороо, бүс нуур, 12610 тоот
 Утас : 80696446
 Цахим хаяг : khandaa_ks@yahoo.com
 Нэгжийн нэр : Химийн шинжилгээний лаборатори
 Шинжилгээний төрөл : Хими
 Шинжилсэн элементийн тоо : 30
 Дээжийн боловсруулалт : -
 Дээжийн тоо, төрөл : 1, ус
 Лабораторийн дугаар : 965-965
 Хүлээн авсан огноо : 2023.02.15
 Шинжилгээ эхэлсэн огноо : 2023.03.06
 Шинжилсэн огноо : 2023.03.13
 Хуудасны тоо : 2

Тайлбар: (1) СУ- Стандарт уусмал

Лабораторийн эрхлэгч
(тэмдэг)



(гарын үсэг)

М.Амгалантуяа
(нэр)

Хяналтын инженер

(гарын үсэг)

С.Одонтуяа
(нэр)

Манай байгууллагаар үйлчлүүлсэнд баярлалаа.

ГСПТ нь MNS ISO/IEC 17025, ISO 17034, ISO/IEC 17043 стандартуудын шаардлага хангасан, Монгол улсын УИТ, Хойд Америкийн Үндэсний итгэмжлэлийн байгууллага /ANAB/-аар үндэсний болон олон улсын түвшинд итгэмжлэгдсэн болно. Шинжилгээний дүн нь захиалагчаас ирүүлсэн тухайн дээжинд хамаарах бөгөөд гарын үсэг, тэмдэг дарсан эх хувь хүчинтэй. Энэхүү баримт бичгийг хуурамчаар үйлдвэл хуулийн хариуцлага хүлээнэ.

18080 м/х-437, Улаанбаатар хот, СХД,
 Үйлдвэрчний эвлэлийн гудамж, ГСПТ-ийн байр,
 Утас: 976-7018 2904; Факс: 976-7018 4212
 Цахим хаяг: info@geocenter.mn; negtseg@geocenter.mn
<http://www.cengeolab.com>

Хэвлэсэн огноо: 3/15/2023
 Хуудас (2/1)

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮГ
ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН



Захиалгын дугаар: ХФ 2023/0175

Захиалагчийн нэр: Элемент ХХК

№	Лаб №	Дээж №	Дээжийн тодорхойлолт	Элемент, мг/л														
				Li	Be	Al	Cr	Mn	Co	Ni	Cu	Zn	As	Mo	Ag	Cd	Ba	Pb
1	965	Ус	-	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1

Чанарын хяналт

1	СУ	Шифр-1151	Стандарт уусмалын утга	0.50	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30
			Шинжилсэн утга	0.40	0.29	0.31	0.29	0.29	0.29	0.31	0.31	0.30	0.29	0.28	0.29	0.29	0.29	0.29
Шинжилгээний аргын код				ICP-25														

№	Лаб №	Дээж №	Дээжийн тодорхойлолт	Элемент, мг/л															
				Rb	Sr	Sn	Sb	Cs	W	Th	U	B	Ca	Fe	K	Mg	Na	Si	
1	965	Ус	-	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.5	10.61	<0.02	0.75	1.72	3.68	5.37

Чанарын хяналт

1	СУ	Шифр-1151	Стандарт уусмалын утга	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	0.30	35.00	0.30	2.50	0.30	6.00	0.30
			Шинжилсэн утга	0.32	0.31	0.33	0.24	0.30	0.30	0.29	0.28	0.27	34.57	0.28	2.26	0.35	6.19	0.31
Шинжилгээний аргын код				ICP-25														

Гүйцэтгэсэн инженер: Б.Номинзаяа, С.Ундраа
(нэр)



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2023/60

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Ус, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: ЭЛЕМЕНТ ХХК

ДЭЭЖИЙН ДУГААР: Ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-207

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, мл: 500

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 0900:2018	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн ерөнхий тоо	MNS ISO 6222:1998	1 мл-д	100	34
2	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
3	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS ISO 19250:2017	25 мл-д	илрэхгүй	илрээгүй
5	Clostridium perfringens	MNS ISO 6461-2:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй

Чанарын менежер

ИТГЭМЖЛЭГДСЭН
ЛАБОРАТОРИ

Д.Пүрэвжаргал

Сорилтын үр дүнд зөвхөн үзсэн дээжид дамжаарна.
Дээжлэлтийн талаарх асуулыг манай лабораторид хариуцаагүй болно.

УИТ0276

ДЭЭЖИЛСЭН ОГНОО: 2023.03.23

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2023.03.23

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2023.04.03

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ХУУДАСНЫ ТОО: 1

Хамтран ажилласан таньд талархлаа.



ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Захиалгын дугаар : ХФ 2023/0176
 Захиалагчийн нэр : Элемент ХХК
 Объект : -
 Хаяг : Налайх дүүрэг, 3-р хороо, бүс нуур 12610 тоот
 Утас : 80696446
 Цахим хаяг : khandaa_ks@yahoo.com
 Нэгжийн нэр : Химийн шинжилгээний лаборатори
 Шинжилгээний төрөл : Хими
 Шинжилсэн элементийн тоо : 30
 Дээжийн боловсруулалт : ГСПТ-д боловсруулсан
 Дээжийн тоо, төрөл : 1, хөрс
 Лабораторийн дугаар : 966-966
 Хүлээн авсан огноо : 2023.02.15
 Шинжилгээ эхэлсэн огноо : 2023.03.06
 Шинжилсэн огноо : 2023.03.15
 Хуудасны тоо : 2

Тайлбар: (1) АСЗ-Аттестатчилсан стандартчилсан загвар
 (2) *Эдгээр элементийн зарим эрдсүүд хэсэгчлэн уусдаг болно.

Лабораторийн эрхлэгч
 (гэмдэг)



(гарын үсэг)

М.Амгалантуяа
 (нэр)

Хяналтын инженер

(гарын үсэг)

С.Одонтуяа
 (нэр)

Манай байгууллагаар үйлчлүүлсэнд баярлалаа.

ГСПТ нь MNS ISO/IEC 17025, ISO 17034, ISO/IEC 17043 стандартуудын шаардлага хангасан, Монгол улсын УИТ, Хойд Америкийн Үндэсний итгэмжлэлийн байгууллага /ANAB/-аар үндэсний болон олон улсын түвшинд итгэмжлэгдсэн болно. Шинжилгээний дүн нь захиалагчаас ирүүлсэн тухайн дээжинд хамаарах бөгөөд гарын үсэг, тэмдэг дарсан эх хувь хүчинтэй. Энэхүү баримт бичгийг хуурамчаар үйлдвэл хуулийн хариуцлага хүлээнэ.

18080 ш/х-437, Улаанбаатар хот, СХД,
 Үйлдвэрчний эвлэлийн гудамж, ГСПТ-ийн байр,
 Утас: 976-7018 2904; Факс: 976-7018 4212
 Цахим хаяг: info@geocenter.mn; negtseg@geocenter.mn
<http://www.cengeolab.com>

Хэвлэсэн огноо: 3/15/2023
 Хуудас (2/1)



ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨУГ
ШИНЖИЛГЭЭНИЙ ДУН

Захиалгын дугаар: ХФ 2023/0176

Захиалагчийн нэр: Элемент ХХК

№	Лаб №	Дээж №	Дээжийн тодорхойлолт	Элемент, мг/кг														
				As	Ba	Bi	Cd	Ce	Co	Cr*	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	966	Хөрс-2, 1.8кг	-	<5	678	<10	<5	74.95	14.13	54.16	32.41	35.09	26.67	897	<5	16.99	823	7.36
Чанарын хяналт																		
1	АСЗ	Шифр-1157	Аттестатчилсан утга	3.18	772	-	103	36.30	222	32.20	55.99	11.08	1007	5.20	162	3709	8.70	
Хүснэгт 3. Хөрсний зүсэлт хийж, дээж авсан цэгийн координат.....	20
Хүснэгт 4. Хөрсний задлан шинжилгээний арга.....	20
Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинжүүд.....	24
Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	24
Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж (мг/кг).....	25
Хүснэгт 8. Хөрсний эрүүл ахуй.....	25
Хүснэгт 9. 1260500119 дугаартай эзэмшил газрын ашиглалтын байдал.....	27
Хүснэгт 10. 1260510271 дугаартай эзэмшил газрын ашиглалтын байдал.....	28
Хүснэгт 11. 1260510340 дугаартай эзэмшил газрын ашиглалтын байдал.....	29

“ЭС ЭНД ЭМ СОЛЬЮШН” ХХК-ийн ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газрын төлөв байдал, ус чанарын захиалгат хянан баталгааг гүйцэтгүүлэхээр захиалга ирүүлсэн “Элемент” ХХК-ийн эзэмшил газрууд нь Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Налайх дүүргийн 3-р хороонд байрлах Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 сарын 30-ны өдрийн А/562 тоот шийдвэрээр олгогдсон 9992 м.кв Эрүүл мэндийн байгууллага, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 сарын 04-ны өдрийн А/56 тоот шийдвэрээр олгогдсон 10000 м.кв үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар, Дүүргийн Засаг даргын 2021 оны 09 сарын 29-ны өдрийн А/231 тоот шийдвэрээр олгогдсон 10021 м.кв үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар нэгж талбарын дугаарууд бүхий 30013 м.кв газар юм.

Хүснэгт 1. Танилцуулга

Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчийн нэр:	“Элемент” ХХК
Эрхлэх үйл ажиллагааны чиглэл:	Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай, эрсдэлтэй хог хаягдал устгах үйлдвэр
Газар ашиглалтын зориулалт:	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн байгууллага • Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар
Өмнө нь хянан баталгаанд хамрагдсан хугацаа:	-
Одоогийн хянан баталгаа хийх шаардлага:	-
Нэгж талбарын дугаар:	1260500119, 1260510271, 1260510340
Регистрийн дугаар:	2100061
Талбайн хэмжээ:	30013 м ²
Хянан баталгааны нэгж талбарын тоо:	3
Захиалагчийн хаяг:	Налайх дүүрэг, 3-р хороо

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. Үндэслэл

Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахыг газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа гэнэ.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг Монгол Улсын “Газрын тухай” хуулийн 6 дугаар бүлгийн 58 дугаар зүйл болон Засгийн Газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3-т зааснаар газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт 5 жилд нэг удаа иргэн, аж ахуй нэгж байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болох бүрд энэхүү баталгааг гаргана.

Хот, сум, суурин газрын хөрсний төлөв байдал, чанар, үржил шимийг дээж авч тодорхойлох, бохирдлын хэмжээ, тархалтыг тогтоох, суурьшлын бүсийн тэлэлтийн байдлыг тогтоох, хяналтын цэг дээр хэмжилт хийж өөрчлөлтийг тодорхойлох, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын сум, орон нутгийн салбарын хянан баталгааны мэдээллийг шинэчлэх, улсын хэмжээнд суурин газрын бохирдлын хэмжээг нэгдсэн арга зүй аргачлалаар тогтоож, газар хамгаалах, нөхөн сэргээх зөвлөмжөөр хэрэглэгчдийг хангахад оршино.

1.2. Ажлын зорилго, зорилт

Зорилго. “Элемент” ХХК-ийн эзэмшил газарт гадаргын төрх, төлөв байдал, хөрсний бохирдолт, хордолт, хөрсний үржил шимийн түвшин зэрэг хөрс, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн талаар хянан баталгааны үндсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан тодорхойлолт, дүгнэлт гаргаж, үйл ажиллагааны чиглэлийг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөхгүйгээр явуулах, хамгаалах, нөхөн сэргээх зөвлөмжийг тайланд тусгах, хянан баталгааны сүлжээний зураг үйлдэж, нэгж талбар тус бүрээр хянан баталгааны паспорт бичиж дүгнэлт өгөхөд оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллана. Үүнд:

1. Эзэмшил талбайн ашиглалтын хил заагийг нарийвчлан тогтоох, тэнд явуулах үйл ажиллагааны онцлогийг харгалзан газар ашиглалтын төрлийг ялгаварлан зураглаж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны нэгж талбаруудад хуваах;
2. Эзэмшил талбайд тархсан хөрсний хил заагийг хээрийн нөхцөлд тогтоох, үүний тулд хөрсний үндсэн болон хагас зүсэлт, ухалт хийж хөрсний ялгаврыг тогтоож, хөрсний дээж авах, дээжид задлан шинжилгээ хийлгэж хөрсний химийн болон физикийн ерөнхий шинж чанар, хөрсөн дэх хүнд металлын агууламж, эрүүл ахуй, төлөв байдлыг тогтоох, хөрсөн бүрхэвчийн эвдрэлд өртсөн байдлыг тодорхойлох;
3. Газрын гадаргын төрх байдал, ашиглалтын өмнөх үеийн хөрсөн бүрхэвчийн өөрчлөлт, эвдрэл, доройтол, зулгаралтын талаар мэдээ цуглуулж, гэрэл зураг авахын зэрэгцээ шаардлагатай газруудад хэмжилт, тодруулалтыг гүйцэтгэх;
4. Ургамлан нөмрөгийн бичиглэл хийх, доройтол, эвдрэлийг тогтоох, тэнд ургаж байгаа ургамлын төрөл зүйлийг тодорхойлох;
5. Үйл ажиллагааны явцад хөрс, ургамал, хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг багасгах, нөхөн сэргээх асуудлаар зөвлөмж гаргах;

1.3. Ажил боловсруулсан аргачлал

Эзэмшил талбайд “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил”-ыг дараах хууль тогтоомжийн заалт, заавар, журмыг баримтлан ажилласан.

Үүнд:

1. “Газрын тухай” хуулийн 6-р бүлгийн 58-р зүйл;
2. 2003 оны Засгийн газрын 28-р тогтоолоор баталсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”;
3. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 34 тоот тушаал “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын заавар”;

4. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 34 тоот тушаал “Хот тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”

1.4. Ажил гүйцэтгэсэн байдал

Налайх дүүргийн 3-р хороонд байрлах “Элемент” ХХК-ийн 3 нэгж талбар бүхий 30013 м² эзэмшил талбайд “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил”-ыг мэргэжлийн эрх бүхий байгууллага “Ай Спешл Инженеринг” ХХК хийж гүйцэтгэлээ.

Тус байгууллагын эзэмшил талбайд “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа”-ны ажлын хээрийн судалгааг 2023 оны 09-р сарын 19-ний өдөр “Ай Спешл Инженеринг” ХХК-ийн газар зохион байгуулагч Ц.Билгүүн, хөрс судлаач У.Будбаатар, ургамал судлаач М.Хоролсүрэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хийж гүйцэтгэв.

ХОЁР. ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

Захиалгат ажлыг Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 02-р сарын 22-ны өдрийн 34 тоот тушаалын 4-р хавсралт “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил”-ын заавар бусад хянан баталгааны аргачилсан зааврыг үндэслэн дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Бэлтгэл ажлын үе шат
- Хээрийн судалгааны үе шат
- Материал боловсруулалтын үе шат
- Баталгаажуулах үе шат

2.1. Бэлтгэл үе шат

Захиалагч байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг, аж ахуй нэгж байгууллагын гэрчилгээ зэрэг холбогдох баримт бичгийг хуулбарлан авч бэлтгэв.

Тухайн эзэмшил газарт “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил” хийгдэж байгаагүй тул өмнөх онтой харьцуулан судлах боломжгүй бөгөөд бид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, харьяа нутаг дэвсгэрт урьд онуудад хийгдэж байсан хянан баталгааны ажлууд, хөрс, ургамлын тоон мэдээ, байгаль орчны судалгаа, цаг уур, байгаль газарзүйн судалгааны материал зэргийг цуглуулж судлан хээрийн судалгаагаар шаардлагатай нэмэлт тодруулалтыг хийхээр бэлтгэсэн. Үүнд:

- Газар ашиглалтын одоогийн хил заагаар эргэлтийн цэгийн дагуу Google earth дээр байршлын зургийг боловсруулав.
- ArcGis программ дээр Google earth-ийн зураг дээр эдэлбэр газрын хил, хөрс, ургамлын тоон зургийг давхцуулж хээрийн судалгааны зураг бэлтгэж урьдчилсан байдлаар хөрсний дээж авах цэг, ургамлын бичиглэл хийх цэгийг тодорхойлсон. (М1:100 000 масштабтай хөрс, ургамлын зураг/ Тоон мэдээлэл)
- Захиалгат хянан баталгааны зааврын хавсралт 3-5, 7-ын дагуу хөрс, ургамлын бичиглэлийг хэвлэж бэлтгэсэн.
- Хөрсний дээж авах уут, цэгийн дугаар бичих самбар, нянгийн эрүүл ахуйн шинжилгээний уут, газар ухах хүрз, жоотуу, метр, шугам, жин, ажлын бээлий,

фото камер, байрлал тодорхойлох GPS, ургамлын бичиглэл хийхэд зориулж 1м²-ын раменски тор зэргийг бэлтгэсэн.

2.2. Хээрийн судалгааны үе шат

Хээрийн судалгааны ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Эзэмшил талбайн газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөгийн төрх, газар ашиглалтын байдал, үйл ажиллагааны явцад бий болсон хог хаягдал, орчны бохирдолт, доройтол зэргийг тогтоосон.
- Хөрс, ургамлын бичиглэл болон зүсэлт хийж, хөрсний үе давхаргаас дээж авсан.
- Хөрсний дээж авсан цэгүүдийн солбицлыг GPS-ээр тодорхойлсон.
- Эдэлбэр газар дээрх байшин барилга бусад объектыг нэг бүрчлэн зураглаж оруулав.

2.3. Материал боловсруулалтын үе шат

Материал боловсруулалтын шатанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Хээрийн судалгааны дүнд эзэмшил газраас авсан хөрсний дээжид агорхими, хүнд металлын үзүүлэлтүүдийг хөрс судлалын лабораторид шинжлүүлэв.
- Хөрсний задлан шинжилгээний дүнг үндэслэн хянан баталгааны тайлан, дүгнэлт, нэгж талбарын сүлжээний зураг, нэгж талбарын тоон мэдээлэл зэргийг боловсруулав.
- Хянан баталгааны тоон мэдээллийг газарзүйн мэдээллийн системийн ArcGIS 10.8, ArcScene, AutoCAD 2016 зэрэг программ хангамжууд ашиглан гүйцэтгэв.
- Орон зайн мэдээллүүдийг WGS-84 солбицлын тогтолцоо, UTM48N тусгаг, Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд хийж гүйцэтгэв.

2.4. Баталгаажуулалтын үе шат

Газрын мониторингийн үндэсний систем буюу Egazar.gov.mn сайтад мэргэжлийн байгууллагын тусгай хандах эрх болон “Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны” үйл ажиллагааг цахим хэлбэрээр эрхлэх, хандах эрхийн дагуу нэвтэрч Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас хэвлэж өгсөн “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийлгэх мэдэгдэх хуудас”-ны дугаараар тухайн нэгж талбарын хянан баталгааны тайлан дүгнэлт, нэгж талбарын сүлжээний зураг, тоон мэдээлэл, хээрийн судалгааны зураг, бусад холбогдох бичиг баримтыг байнгын шинжээчид илгээнэ.

Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”-ын 7-д “Аймаг, нийслэлийн газрын

албаны дарга нь хянан баталгааны байнгын шинжээч байна. Мөн Барилга хот байгуулалтын Сайдын 2019 оны 34 тоот тушаал “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын заавар”-ын 4.6-д хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах гэж заасан байдаг. Байнгын шинжээч нь тухайн аймаг, нийслэл дүүргийн хэмжээнд хийгдсэн бүх төрлийн хянан баталгааны мэдээллийн сан хөтлөх, хяналт тавих зэрэг чиг үүрэгтэй ажилладаг.

Дүүргийн газар зохион байгуулалтын албаны дарга бөгөөд байнгын шинжээчээр ажлын 10-15 хоногт баталгаажиж гарсан 2 хувь хянан баталгааны дүгнэлтийг, мэргэжлийн байгууллагын боловсруулсан тайлангийн хамт “Элемент” ХХК-ийн менежер Б.Ундармаа-д хүлээлгэн өгөх.


ГУРАВ. БАЙГАЛЬ, НУТАГ ДЭВСГЭРИЙН МЭДЭЭЛЭЛ

3.1 Газарзүйн байршил

Улаанбаатар хот орчим нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, хөрсний хөлдөлтийн гүн нь 2-3 м хүрнэ. Ихэнхдээ хойд болон баруун хойд зүгээс салхилдаг. Тус газрын газрын гадаргын өндөршилт нь далайн түвшингээс дээш 1330-1380 метрийн хооронд хэлбэлздэг. Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужид орших Хэнтийн захын уулсын тойрогт багтана. Тус муж нь Монгол орны зүүн хойт захад оршино. Түүний хил зааг төдийлөн тодорхой биш боловч баруун тал нь Туул, Орхон голын хөндий, хойт талд улсын хил зүүн хэсэгтээ Онон голын зүүн Хэрлэнгийн дунд бие хүртэл өмнөт талынх нь хил Хэрлэнгийн хөндий ба Хэрлэнгийн урд тохой хүрнэ.

Судалгааны талбай нь засаг захиргааны байршилаар Налайх дүүргийн 3-р хороонд далайн түвшнээс дээш 1396 метрийн өндөрт байрлана.


Зураг 1. “Элемент” ХХК-ийн эзэмшил талбайн байршил



3.2 Газрын гадарга

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны шувтрах үзүүр Асралт хайрхан (2799 м) уулын өвөр талаар Богд хан уулын ар хормойд (дундаж өндөр нь 1350 м) Туул голын сав газарт байрлах бөгөөд Чингэлтэй уул (1949 м), Баянзүрх уул (1834 м), Богд хан уул (2256 м), Сонгинохайрхан уул (1652 м) гэсэн уулсуудаар хүрээлэгдэж оршино. Нийслэл Улаанбаатар хотын барилгажсан ба барилгажих талбай нь дапайн түвшнээс дээш 1260-1350 м өндөр, газрын гадаргуу нь бүхэлдээ хойд уулсаас Туул голын сав хөндий чиглэсэн налуугийн тогтолцоотой юм. Талбайн үнэмлэхүй өндөр 1200-1500 м байна. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн өндөр цэг нь Богдхан уулын ноён оргил Цэцээ гүн (2256 м), хамгийн нам цэг нь Туул голын хөндийд орших Шувуун фабрикийн район (1203 м) болно.

Зураг 2. Улаанбаатарын өндөржилтийн зураг



Эх үүсвэр: 2019 он (Srtm хиймэл дагуулын 4/23/2014-ны мэдээ ашиглав).

◆ Физик газарзүйн мужлал

Монгол орны физик газарзүйн мужлалын хувьд төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбай Улаанбаатар хот бүхэлдээ Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтрага үзүүрт, Хэнтийн захын

хэсгийн тойрогт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг.

Хэнтийн захын тойрог- Тус тойрогт жинхэнэ ойт хээрийн ландшафт ноёрхоно. Уулын ар хажуунууд дээд биеээрээ хар мод, хус, улиасаар бүрэлдсэн. Улаанбаатар районы тектоник тогтоц Хэнтийн уулархаг нутгийн неотектоник хөгжилтэй шууд холбоотой бөгөөд неоструктурын ерөнхий төлвийг Улаанбаатар хотын грабень, түүнийг хүрээлэн орших блоклог өргөгдлүүд тодорхойлно.

◆ **Байгалийн мужлал**

Судалгааны талбай орчим нь байгалийн мужлалтийн хувьд Хэнтэйн хөмбөн уулт өндөрлөгийн мужийн Хэнтэйн уулт өндөрлөгийн төв хэсгийн тайга, ян сарьдгийн дэд мужийн умард хуурай хээрийн (20-30%), ой (10-20%), нуга (10%-аас бага) ойт хээрийн мужлалд хамаарах ба гадаргын хотгор 20%-аас доош байна.

◆ **Ландшафт**


Судалгааны талбай орчмын хэмжээнд уулын ландшафтийн ангийн, дундаж өндөр уулын дэд ангийн (1500-2500 метр хүртэл) эвдрэл элэгдлийн төрлийн ойт хээрийн хэв шинж болон умард хуурай хээрийн ландшафтийн хэв шинж, харин Туул, Сэлбэ голын хөндий дагууд хотгорын ландшафтийн ангийн, тэгш гадаргатай хуримтлалын төрлийн умард хуурай ландшафтийн хэв шинжүүд тархана.

◆ Газар хөдлөлтийн бичил мужлал

Хүснэгт 2. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бүсчлэл

№	Газар хөдлөлийн бүс (Баллын шатлалаар)	Хамаарах хэсэг
1	VI баллын газар хөдлөлтийн бүс	Баянзүрх дүүргийн XII хороолол, Баянгол дүүргийн III; IV хорооллын зарим хэсэг
2	VII баллын газар хөдлөлтийн бүс	Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг бүхэлдээ Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн зарим хэсэг
3	VIII баллын газар хөдлөлтийн бүс	I; X хороолол, Дунд гол, Туул, Сэлбэ голын сав газар , Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр

Зураг 3. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн зураг



Улаанбаатар хотын хүрээнд инженер-сейсмологийн судалгаа анх 1967 онд болсон Могодын газар хөдлөлийн давтамжаар хийж , газар хөдлөлийн бичил мужлалын бүдүүвч зургийг анх зохиох зөвлөмжийг боловсруулж байсан ч нарийвчлан судалсан ажил хийгдээгүй байна. Дээрхи хүснэгтээс үзэхэд судалгааны талбайн орчмын нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бүсчлэлийн хувьд VIII баллын газар хөдлөлтийн эрсдэлтэй бүсэд хамаарагдаж байна.

3.3 Цаг уур

Монгол орны уур амьсгалын мужлалтын хувьд авч үзвэл Улаанбаатар хот нь хуурайдуу сэрүүн зунтай, хахир хүйтэн өвөлтэй нутагт багтана. (Цаг уур орчны шинжилгээний газар, 2016). Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь хасах 49°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 38.6°C, үнэмлэхүй их бага температурын агууриг нь 87.6°C болдог эрс тэс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь -3°C, “хамгийн хүйтэн” 1-р сарын температур нь -26°C байх бөгөөд -30°C-аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна. (Нийслэлийн статистикийн газар, 2016, р. 4).

А. Агаарын температур: Улаанбаатар хотын жилийн дундаж агаарын температур сүүлийн жилүүдэд хотын салхины дээд талд буюу баруун хэсэгт байрлалтай Улаанбаатар станцад 1.3°C, хотын төвд байрлалтай Их сургууль станцад 1.5°C, хотын өмнө хэсэгт Туул голын хөндийд байрлалтай Буянт-ухаа станцад 1.6°C, хотын агаарын бохирдол, их даралтын орны нөлөөгөөр үүсдэг температурын инверсэд орших Морин уул станцад 1.6°C-аар тус тус дулаарсан байна.

Б. Хөрсний гадаргын дундаж температур: Улаанбаатар, Их сургууль станцуудын хөрсний гадаргын жил, жилийн дундаж температурын өөрчлөлтийн зургаас харахад Улаанбаатар станцад 0.7°C-аар, Их сургууль станцад 0.3°C-аар тус тус дулаарсан байна.

В. Үнэмлэхүй чийг: Улаанбаатар хотод үнэмлэхүй чийгшлийн олон жилийн явц нь усны уурын даралт, агаарын температураасаа хамаарч өвөл 0.7-2.2 гПа, зун 8.5-13.1 гПа байдаг.

Г. Харьцангуй чийгшил: Харьцангуй чийгшлийн хэмжээ агаарын температураас урвуу хамааралтай бөгөөд үүл хур тунадаснаас хамаарна. Улаанбаатар хот орчимд жилийн дундаж харьцангуй чийгшил 55-76% байдаг.


Д. Дутагдал чийг: Дутагдал чийгшил нь агаар усны уураар ханатал хэдий хэмжээний чийг дутуу байгааг үзүүлдэг. Өвлийн улиралд агаарын температур бага учир ханасан байдалдаа ойр байх тул дутагдал чийгийн хамгийн бага 0.3-1.7 гПа, зундаа дунджаар 7.0-9.4 гПа байна. (Улаанбаатар хотын цаг уур орчны шинжилгээний газрын цахим хуудас, <http://ulaanbaatar.tsag-agaar.gov.mn>)

3.4 Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын газар нутаг нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын Хангайн их мужийн өндөршилийн бүсчлэлийн Хэнтийн мужийн Хэнтийн захын тойрогт багтана. (МУ-ын Үндэсний Атлас, 2009)

“Элемент” ХХК-ийн эзэмшил газар нь Улаанбаатар хотын зүүн хэсэгт, Налайх дүүргийн 3-р хорооны нутагт байрлах бөгөөд хөрсөн бүрхэвчийн ерөнхий төлөвийг ГЗБГЗЗГ-н архив мэдээллийн төвийн М1:100 000 масштабтай хөрсний зургийн тоон мэдээллээс зургаар харуулав.

Зураг 4. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг



Зургаас харахад эзэмшил газар орчмоор уулын хар шороон хөрс, хар хүрэн хөрс, ердийн хөгжилтэй хөрс тархсан бөгөөд “Элемент” ХХК-ийн эзэмшил газар нь хар хүрэн хөрсний хэв шинжид хамаарна.

Хар хүрэн хөрс – Ердийн хөрсний тархалтын хил зааг доторх харьцангуй хотос, хонхор газраар, тухайлбал уулын бэл хормой, ухаа толгодын хоорондох хотгорын ёроол, нуур, голын дэнж зэрэг нам газрыг дагаж тархах бөгөөд үетэн-алаг өвст ургамлын бүрхэц 95, 60-80% 95. Энэ хөрсний ялзмаг хуримтлалын (А) давхаргын


зузаан дунджаар 27 см (хамгийн бага нь 10-15 см, хамгийн их нь 35-45 см), нийт ялзмагт (А+В1) үеийн зузаан дунджаар 48 см (хамгийн нимгэн нь 20-25 см, хамгийн зузаан нь 60-80 см) байх бөгөөд өнгө нь илүү бараан туяатай ялзмагийн халтартсан өнгөр толбо элбэгтэй, нэлдээ саарал туяа зонхилно. Ялзмаг хуримтлалын давхаргын дээд хэсэг (0-10 см) дэх органик бодисын хэмжээ 2-6% хүртэл хэлбэлзэх ба гүн рүүгээ ялзмагийн агууламж аажим буурна. (Д.Доржготов - Монгол орны хөрс 2003)

3.5 Ургамлын нөмрөг

Монгол орны орчин үеийн ургамалжилтын тархалтад голлон нөлөөлөх хүчин зүйл нь газар нутгийн хэмжээ, хотгор гүдгэр юм. Монгол орны ургамалын тархалтын зүй тогтол, ургамлын хэв шинжүүд, ургамал газарзүйн мужыг ялгаж гаргасан байна. Энэхүү мужлалд 1950 онд А.А Юнатовын боловсруулсан ургамал-газар зүйн дэлгэрэнгүй мужлалтыг авчээ. Энэ мужлалтад ургамал-газар зүйн аймгийг голлох ургамлын аймгийн шинж чанараар, түүний үүсэл хөгжлийн түүхийн үүднээс ялгаж муж, тойрог, районыг ургамлын хэв шинжээр тогтоосон ба тус бүрийн нь хотгор гүдгэр, хурдас чулуулгийн онцлогийг товч тодорхойлсон нь газарзүйн ихээхэн үндэслэлтэй болсон юм.

Тус судалгааны талбай нь Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн хувьд ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Хэнтийн уулын тайгын тойрогт хамаарагдана. Хэнтийн уулын тайгын тойрогт Хэнтийн уулсын төв, Хэнтий-Дагуурын нурууны баруун өмнөд шувтаргын нурууны төв хэсэгт багтана. Энэ тойрогт нийт 1276 зүйл гуурст ургамал тархсан ба Дорнод Сибирийн ялангуяа Дагуурын тайга, өндөр уулын ургамлын аймгийн төлөөлөгчид голчлон тохиолдоно. Зөвхөн энэ тойрогт 62 зүйл (Urgamal et al. 2016) ургамал ургана.

Зураг 5. Монгол орны ургамал газарзүйн мужлал



Эх сурвалж: Монгол Улсынн атлас 2009 он

ДӨРӨВ. ХӨРСНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАР, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

4.1 Хөрсний дээж авсан цэгүүд, шинжилгээний аргууд

“Элемент” ХХК-ийн эзэмшил талбайд хөрсний зүсэлт хийж агрохимийн, хүнд металлын болон эрүүл ахуйн дээж авч “Ланд Овнер” ХХК-ийн хөрс судлалын “Грийн Лаб” лабораторид задлан шинжлүүлсэн.

Тус дээжид хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд болох хөрсний урвалын орчин, хөрсний давжилт буюу цахилгаан дамжуулах чанар, ялзмагийн агууламж, солилцох сууриуд, шим тэжээлийн бодисын агууламж, физикийн үндсэн шинж

болох хөрсний механик бүрэлдэхүүн болон хүнд металлын бохирдол, хөрсний эрүүл ахуй зэрэг үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.

Хүснэгт 3. Хөрсний зүсэлт хийж, дээж авсан цэгийн координат

Хөрсний дээж авсан цэг		
D-001	47.7674059° N	107.300560°E
D-002	47.74629° N	107.3015725°E
D-002	47.7673561° N	107.3031268°E

Хүснэгт 4. Хөрсний задлан шинжилгээний арга

№	Хөрсний задлан шинжилгээний үзүүлэлтүүд	Задлан шинжилгээний аргууд
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Каченский арга, %
2	Хөрсний урвалын орчин	Усанд ханданд ионометрийн арга
3	Хөрсний ялзмаг	Тюрингийн арга, %
4	Хөрсний давс	Ионометрийн арга, %
5	Хөрсний цахилгаан дамжуулах чанар	Ионометрийн арга, dS/m
6	Хөрсний карбонатын агууламж	Кальциметрийн арга, %
7	Солилцох сууриуд /Ca, Mg/	Комплексметрийн арга, мг-экв/100 гр
8	Хөрсний хөдөлгөөнт фосфор /P ₂ O ₅ /	1 хувь нүүрс хүчлийн аммоны уусмалд Мачигины арга, мг/100 гр
9	Хөрсний хөдөлгөөнт кали /K ₂ O/	1 хувь нүүрс хүчлийн аммоны уусмалд дөлийн фотометрийн арга, мг/100 гр
10	Хүнд металлууд (Cr, Pb, Cd, Ni, Zn)	Атомын шингээлтийн спектрофотометрийн

Зураг 6. Хөрсний зүсэлт хийж, дээж авсан цэгийн байршил



4.2. Хөрсний төлөв байдал, шинж чанар

- **Талбайн байршил:** Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, “Элемент” ХХК-ийн эзэмшил талбай
- **Огноо:** 2023-09-19
- **Зүсэлт цэгийн байршил:** 1260500119 дугаартай нэгж талбарын зүсэлт
- **Зүсэлт хийсэн цэгийн өндөр /м/:** 1388 м
- **Газрын гадарга:** Тэгшивтэр **Гадаргын налуу:** 1-2 градус



- **Хөрсний нэр:** Хар хүрэн хөрс
- **Хөрсний код:** 2202

- **Хөрсний эвдрэл:** Бага зэрэг өртсөн
- **Хөрс үүсгэгч чулуулаг:** Элюви-делювийн хурдас
- **Эвдрэлийн хэлбэр:** Хүн, техник, салхи, усны



А үе (0-20 см): Хар хүрэн өнгөтэй чийглэг, нүх сүвэрхэг бөөмөн бүтэцтэй, ургамлын үндэс дунд зэрэг тархсан, хайрга чулууны агууламж бага зэрэг, шавранцар механик бүрэлдэхүүнтэй, дараагийн үе давхаргын шилжилт өнгөөр аажим,

- **Талбайн байршил:** Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, “Элемент” ХХК-ийн эзэмшил талбай
- **Огноо:** 2023-09-19
- **Зүсэлт цэгийн байршил:** 1260510271 дугаартай нэгж талбарын зүсэлт
- **Зүсэлт хийсэн цэгийн өндөр /м/:** 1387 м
- **Газрын гадарга:** Тэгшивтэр **Гадаргын налуу:** 1-2 градус



- **Хөрсний нэр:** Хар хүрэн хөрс
- **Хөрсний код:** 2202
- **Хөрсний эвдрэл:** Бага зэрэг өртсөн
- **Хөрс үүсгэгч чулуулаг:** Элюви-делювийн хурдас



- **Эвдрэлийн хэлбэр:** Хүн, техник, салхи, усны
- А үе (0-20 см):** Хар хүрэн өнгөтэй чийглэг, нүх сүвэрхэг бөөмөн бүтэцтэй, ургамлын үндэс дунд зэрэг тархсан, хайрга чулууны агууламж бага зэрэг, шавранцар механик

бүрэлдэхүүнтэй, дараагийн үе давхаргын шилжилт өнгөөр аажим,

➤ **Талбайн байршил:** Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, “Элемент” ХХК-ийн эзэмшил талбай

➤ **Огноо:** 2023-09-19

➤ **Зүсэлт цэгийн байршил:** 1260510340 дугаартай нэгж талбарын зүсэлт

➤ **Зүсэлт хийсэн цэгийн өндөр /м/:** 1387 м

➤ **Газрын гадарга:** Тэгшивтэр **Гадаргын налуу:** 1-2 градус



➤ **Хөрсний нэр:** Хар хүрэн хөрс

➤ **Хөрсний код:** 2202

➤ **Хөрсний эвдрэл:** Бага зэрэг өртсөн

➤ **Хөрс үүсгэгч чулуулаг:** Элюви-делювийн хурдас

➤ **Эвдрэлийн хэлбэр:** Хүн, техник, салхи, усны



А үе (0-20 см): Хар хүрэн өнгөтэй чийглэг, нүх сүвэрхэг бөөмөн бүтэцтэй, ургамлын үндэс дунд зэрэг тархсан, хайрга чулууны агууламж бага зэрэг, шавранцар механик бүрэлдэхүүнтэй, дараагийн үе давхаргын шилжилт өнгөөр аажим,

4.2.1 Хөрсний лабораторийн шинжилгээний дүн

Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинжүүд

Дээж авсан гүн /см/	рН	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaC O ₃	Ca+ Mg	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
							Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Дээж-1260500119										
0-30	8.02	0.02	0.04	3.21	0.00	22.2	18.4	3.8	2.5	28
Дээж-1260510271										
0-30	7.82	0.03	0.069	3.22	0.00	25.6	24.2	1.4	2.1	31
Дээж-1260510340										
0-30	7.96	0.04	0.088	3.16	0.49	22.1	18.3	3.8	2.6	33

“Элемент” ХХК-ийн эзэмшиж буй 1260500119, 1260510271, 1260510340 дугаартай нэгж талбаруудаас авсан хөрсний дээжний лабораторийн шинжилгээний дүгнэлт:

Хөрсний урвалын орчин рН нь дунд шүлтлэг шинжтэй, карбонатын агууламж бага зэрэг. Ургамалд ашиглагдах тэжээлийн элементүүдийн хангамжийн хувьд: Хөдөлгөөнт фосфор (P₂O₅) дунд, солилцох кали (K₂O) сайн хангамжтай, ялзмагийн хэмжээ дунд агууламжтай байна.

Солилцох чадварын хувьд: Хөрсний солилцох шингээлтийн катионы бүрэлдэхүүнд Ca, Mg голлон оролцоно. Энэ үзүүлэлт нь хөрсний бүрэлдэхүүн, шингээх чадвар зэргийг илэрхийлнэ. Ca+Mg дундаж агууламж нь солилцох сууриудын чадвар дунд зэрэг байна.

Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлтийн дугаар	Дээж авсан гүн /см/	Механик ширхгүүд, %, ширхгийн хэмжээ, мг							Механик бүрэлдэхүүн
		1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
Дээж-01	0-30	16.0	44.6	7.4	14.9	10.5	6.6	32.0	Шавранцар
Дээж-02	0-30	14.6	42.9	18.2	7.4	9.2	7.7	24.3	Шавранцар
Дээж-02	0-30	11.1	24.4	26.5	10.5	17.2	10.4	38.1	Шавранцар

Хээрийн судалгаагаар хийгдсэн хөрсний дээжүүд нь эзэмшил талбайн хөрсийг шавранцар механик бүрэлдэхүүнтэй хар хүрэн хөрс гэдгийг илэрхийлж байна.

4.2.2. Хөрсөн дэх хүнд элементүүдийн агууламж

Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаанд хадгалагдаж усаар, агаарын тоосонцроор дамжин мал, амьтан, хүний бие организмыг хордуулдаг байна.

Хөрсөн дэх хүнд элементийн агууламжийн дээжийг өнгөн хөрснөөс авагдсан дээжид 6 үндсэн элементээр тодорхойлуулсан ба Монгол улсын стандарт “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-

ийн дүнг үндэслэн элемент тус бүрээр стандартын хүлцэх агууламжийн үзүүлэлттэй харьцуулалт хийсэн.

Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж (мг/кг)

Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд							
Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж-01	0-20	37.1	19.2	-	48.9	20.6	30.5
Дээж-02	0-20	54.2	14.8	-	39.7	14.4	28.7
Дээж-03	0-20	50.6	21.0	-	38.1	21.1	23.3
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019							
Шавранцар хөрс		100.0	70.0	1.5	150.0	80.0	100.0

Дээрх дээжнүүдэд Кадми (Cd) илрээгүй ба бусад хүнд металлуудын агууламж стандартад заагдсан хүлцэх агууламжийн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд байх хэмжээнээс харьцангуй бага буюу бохирдолгүй гарсан байна.

Хүснэгт 8. Хөрсний эрүүл ахуй


№	Лаборатори йн дугаар	Нянгийн тоо MNS 63416:2012	Гэдэсний савханцрын Титр (E.Coli) MNS5367:2004			Анаэробын (Cl.perfringens) MNS6341:2012	
		Шинжилгээн ий хариу	Шинжилгээн ий хариу	Бохирдлы н зэрэг	Шинжилгээн ий хариу	Бохирдлы н зэрэг	
1	23/6450	1.4*10 ⁵	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
2	23/6451	2.2*10 ⁵	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
3	23/6452	1.7*10 ⁵	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	

Хөрсний эрүүл ахуй нянгийн шинжилгээнээс үзэхэд нэгж талбарын хөрсөнд гэдэсний савханцарын титр болон Анаэробын илрээгүй эрүүл байна. Цаашид эзэмшил талбайгаас хөрсний дээж авч шинжлүүлж бохирдлын түвшинг тухай бүр тодорхойлуулах ажлыг үргэлжлүүлэн хийх хэрэгтэй.

ТАВ. УРГАМЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ШИНЖ ЧАНАР

Ургамалжилтын судалгааг хийхдээ ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэцийг геоботаникийн хээрийн судалгааны ерөнхий арга зүйгээр тодорхойлсон. “Элемент” ХХК-ийн эзэмшил талбай нь Налайх дүүргийн 3-р хороонд хот, суурингийн бүсэд хамрагдаж байна. Судалгааны талбайн Х-1-2-7 Хялгана-биелэгт өвст ангиллын бэлчээрт хамаарах ба хялгана, хиаг, бушилз, зэрэг ургамлууд хагдралтын үедээ байна.

Зураг 7. Эзэмшил талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдал



ЗУРГАА. ГАЗАР АШИГЛАЛТЫН БАЙДАЛ, ГАЗРЫН ГАДАРГЫН ЭЛЭГДЭЛ ЭВДРЭЛ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

6.1. Газар ашиглалтын байдал


Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын судалгаа материал боловсруулалтын ажлын үр дүнд “Элемент” ХХК-ийн захиалгаар Улаанбаатар хот Налайх дүүргийн 3-р хороонд байрлах Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 сарын 30-ны өдрийн А/562 тоот шийдвэрээр олгогдсон 9992 м.кв, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 сарын 04-ны өдрийн А/56 тоот шийдвэрээр олгогдсон 10000 м.кв , Дүүргийн Засаг даргын 2021 оны 09 сарын 29-ны өдрийн А/231 тоот шийдвэрээр олгогдсон 10021 м.кв тус тус газруудыг үндэслэн газрын гадаргын төрх байдал, ашиглалтыг харгалзан үзэж төлөв байдлыг тодорхойлон нэгж талбарын паспорт бичиж баталгаажуулав.

Хүснэгт 9. 1260500119 дугаартай эзэмшил газрын ашиглалтын байдал

Газар ашиглалтын төрөл	Талбай /м ² /	Бохирдлын төрөл		
		Физикийн	Химийн	Биологийн
Шийдвэрээр олгосон талбай	9992.0	+	-	-
Мэдээллийн сангийн талбай	9992.0	+	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	9961.0	+	-	-
Илүү ашиглаж буй талбай	-	+	-	-
Дутуу ашиглаж буй талбай	31.0	+	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	9961.0	+	-	-
Сул чөлөөтэй талбай	812.1	-	-	-
Ногоон байгууламж	2298.1	-	-	-
Халцарсан талбай	1023.0	+	-	-
Барилга байгууламж	1871.3	+	-	-
Хаягдлын далан	1723.1	+	-	-
Хатуу хучилттай талбай	2233.4	+	-	-

“Элемент” ХХК-ийн 1260500119 дугаартай нэгж талбар нь 9992 м.кв ба нийт газрын 6851.7 м.кв талбай үйл ажиллагаанд өртсөн ба 812.1 м.кв талбай сул чөлөөтэй байна. Эзэмшил газрын урд хэсэгт 31.0 м.кв талбай дутуу ашиглаж байна.

Зураг 8. Эзэмшил газрын сүлжээний зураг




Хүснэгт 10. 1260510271 дугаартай эзэмшил газрын ашиглалтын байдал

Газар ашиглалтын төрөл	Талбай /м ² /	Бохирдлын төрөл		
		Физикийн	Химийн	Биологийн
Шийдвэрээр олгосон талбай	10000.0	+	-	-
Мэдээллийн сангийн талбай	10000.0	+	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	10434.0	+	-	-
Илүү ашиглаж буй талбай	434.0	+	-	-
Дутуу ашиглаж буй талбай	-	+	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	10000.0	+	-	-
Сул чөлөөтэй талбай	754.1	-	-	-
Барилга байгууламж	1907.6	+	-	-
Халцарсан талбай	6197.0	+	-	-
Чингэлэг	34.3	+	-	-
Материал хураасан талбай	802.0	+	-	-
Хатуу хучилттай талбай	305.0	+	-	-

“Элемент” ХХК-ийн 1260510271 дугаартай нэгж талбар нь 10000.0 м.кв ба нийт газрын 9245.9 м.кв талбай үйл ажиллагаанд өртсөн ба 754.1 м.кв талбай сул чөлөөтэй байна. Эзэмшил газрын урд хэсэгт 434.0 м.кв талбай илүү ашиглаж байна.

Зураг 9. Эзэмшил газрын сүлжээний зураг




Хүснэгт 11. 1260510340 дугаартай эзэмшил газрын ашиглалтын байдал

Газар ашиглалтын төрөл	Талбай /м ² /	Бохирдлын төрөл		
		Физикийн	Химийн	Биологийн
Шийдвэрээр олгосон талбай	10021.0	+	-	-
Мэдээллийн сангийн талбай	10021.0	+	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	10237.4	+	-	-
Илүү ашиглаж буй талбай	342.7	+	-	-
Дутуу ашиглаж буй талбай	126.3	+	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	9894.7	+	-	-
Сул чөлөөтэй талбай	3565.1	-	-	-
Барилга байгууламж	512.3	+	-	-
Халцарсан талбай	5366.9	+	-	-
Материал хураасан талбай	96.0	+	-	-
Хатуу хучилттай талбай	354.4	+	-	-

“Элемент” ХХК-ийн 1260510340 дугаартай нэгж талбар нь батлагдсан кадастрын зургаас 126.3 м.кв талбай дутуу 342.7 м.кв талбай илүү буюу газар дээрээ 10237.4 м.кв талбай ашиглаж байна. Нийт зөвшөөрөлтэй талбай нь 64 орчим хувь нь элэгдэл эвдрэлд орсон үлдсэн талбай сул чөлөөтэй байна.

Зураг 10. Эзэмшил газрын сүлжээний зураг



6.2. Эвдэрч, доройтсон газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний зөвлөмж

- “Элемент” ХХК нь газар эзэмших гэрээнд заасан нийтийн эзэмшлийн зам талбайн орц гарцыг чөлөөтэй байлгах, өөрийн эзэмшил газар дээр барилгын өргөтгөл, шинэчлэлтийг зохих зөвшөөрлийн дагуу хийх, эзэмшилд олгогдсон газрын хил хязгаарыг газар дээр нь хүлээлгэн өгөх, газрын хэмжээ зориулалтыг өөрчлөхгүй байх, бусдын газар эзэмшилтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх шаардлагыг биелүүлэх хэрэгтэй.
- Газрын мэргэжлийн байгууллагын баталсан кадастрын зургийн дагуу хашаа хайсыг татах, эсвэл одоо ашиглаж байгаа талбай нь дагуу кадастрын зургийг шинэчлүүлж мэргэжлийн байгууллагад талбай нь хэмжээ өөрчлөлх хүсэлт гаргах шаардлагатай.
- Автомашин болон явган хүн тогтмол зорчдог хэсэгт зориулалтын зам талбай байгуулж орчны тоосжилт болон бохирдлоос сэргийлэх.
- Хавар, намрын хуурайшилтын үед эдэлбэр газарт усалгаа, тордлогоог тухай бүр хийх, орчны хуурайшилт, тоосжилт, ургамлан нөмрөгийн талхлагдалт болон бусад байгаль орчинд нөлөөлж болохуйц эрсдэлээс сэргийлж ажиллах, намар хагдарсан өвсийг хадаж гал түймрээс сэргийлэх, орц гарцын болоод өндөр хүчдэл зэрэг газар ашиглалтын аюулгүй байдлын зөрчил үүсгэлгүйгээр ашиглах нь зүйтэй;
- Ашиглах боломжгүй, бүрэн бүтэн байдал нь алдагдсан бараа материалыг зориулалтын хог хаягдлын цэгт хаях, хураасан материалын эмх цэгцийг сайжруулж газрыг үр ашигтай, зохистой ашиглах;
- Газрын тухай хуульд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын хянан баталгаагаар тогтоогдсон хөрсний үржил шим эрс доройтсон, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, хөрс хамгаалах арга хэмжээ авалгүй ашиглалтыг үргэлжлүүлж хөрсийг доройтуулсан нөхцөлд Газрын тухай хуулийн 40-р зүйл, газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох арга хэмжээ авах тул хөрс хамгаалах арга хэмжээг мөрдлөг болгон ажиллах;

- “Газрын тухай хууль”-ийн 48 дугаар зүйл 48.1-д заасныг зөрчихгүй байх үүднээс нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг газарт бэхлүүлж тусгаарлах хашаа хайсаар хамгаалах, орц гарц шийдвэрлэхэд анхаарах.
- Тус компани нь Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу 5 жил тутамд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг гаргуулж байх шаардлагатай.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

“Элемент” ХХК-ийн захиалгаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд орших 9992 м², 10000 м², 10021 м² бүхий гурван талбайд “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа”-ны ажлыг гүйцэтгэж дараах дүгнэлтийг өгч байна.

Хянан баталгааны нэгж талбарт хээрийн судалгаагаар хийгдсэн хөрсний дээжүүд нь шавранцар механик бүрэлдэхүүнтэй хар хүрэн хөрс тархсан. Хөрсний урвалын орчин рН нь сул шүлтлэг шинжтэй, карбонатын агууламж бага зэрэг.

Ургамалд ашиглагдах тэжээлийн элементүүдийн хангамжийн хувьд: Хөдөлгөөнт фосфор (P₂O₅) дунд, солилцох кали (K₂O) сайн хангамжтай, ялзмагийн хэмжээ дунд агууламжтай байна.

Солилцох чадварын хувьд: Хөрсний солилцох шингээлтийн катионы бүрэлдэхүүнд Са, Mg голлон оролцоно. Энэ үзүүлэлт нь хөрсний бүрэлдэхүүн, шингээх чадвар зэргийг илэрхийлнэ. Са+Mg дундаж агууламж нь солилцох сууриудын чадвар дунд зэрэг байна.

“Элемент” ХХК-ийн эзэмшил газар нь нийт 3 нэгж талбарын 30013 м.кв бөгөөд газар дээрээ 30632.4 м.кв талбай ашиглаж байна. Нийт талбайн 17 орчим буюу 5131.3 м.кв талбай сул чөлөөтэй байгаа бол үлдсэн талбайд барилга байгууламжийн ажил болон машин техникийн нөлөөгөөр эвдэрсэн байна.

“Элемент” ХХК нь цаашид хавар, намрын хуурайшилтын үед эдэлбэр газарт усалгаа, тордлогоог тухай бүр хийх, орчны хуурайшилт, тоосжилт, ургамлан нөмрөгийн талхлагдалт, болон бусад байгаль орчинд нөлөөлж болохуйц эрсдэлээс сэргийлж ажиллах, намар хагдарсан өвсийг хадаж гал түймрээс сэргийлэх, орц гарцын болоод өндөр хүчдэл зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал зөрчилгүй явуулах нь зүйтэй.

Хөрсний бохирдлын босго утга болон хүнд металлын агууламж стандартад заасан үзүүлэлтээс бага байгаа хэдий ч “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүнд металлын шинжилгээ авч лабораторид шинжлүүлэхэд Кадми (Cd) илрээгүй ба бусад хүнд металлуудын агууламж стандартад заагдсан хүлцэх агууламжийн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд байх хэмжээнээс харьцангуй бага буюу бохирдолгүй гарсан байна. Цаашид эзэмшил талбайгаас хөрсний дээж авч шинжлүүлж бохирдлын түвшинг тухай бүр тодорхойлуулах ажлыг үргэлжлүүлэн хийх хэрэгтэй.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жилийн дараа дахин тодруулах үүргийг 1260500119, 1260510271, 1260510340 нэгж талбаруудыг эзэмшигч “Элемент” ХХК-ийн менежер Б.Ундармаа хариуцна.

НАЙМ. АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын “Газрын тухай” хууль. 2002 он
2. Монгол улсын үндэсний атлас. 2009 он
3. ГХГЗЗГ азар. Монгол орны газарзүйн атлас. 2004 он
4. МУ-ын засгийн газар 28-р тогтоол. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан хийх журам. 2003 он
5. Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 02-р сарын 22-ны өдрийн 34 тоот тушаалын Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын заавар;
6. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22- өдрийн 34 тоот тушаал Хот тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хяна баталгааны ажлын аргачилсан заавар;
7. Д.Доржготов, Монгол орны хөрс. УБ. 2003 он
8. Одгэрэл Б.Буянбаатар А. Хөрс судлал. УБ. 2011
9. “Монгол орны зонхилох ургамлын лавлах” УБ. 2000 он
10. А.А.Юнатов, “БНМАУ-ын ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд, УБ. 1976
11. MNS 3298-90. Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага;
12. MNS 3297-91. Байгаль хамгаалал, Хот суурины газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ;
13. MNS 5850:2019. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
14. М1:100 000 масштабтай хөрс, ургамлын зураг (Тоон мэдээлэл)
15. Монгол орны хөрсний нэршил ба код
16. Монгол орны бэлчээр, хадлангийн ангилал ба өнгөний код
17. БОАЖЯ. Байгаль орчны мэдээллийн сан. (www.eic.mn)
18. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
19. Google earth болон Sasplanet, Terra